

“БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ”
ТОГТООЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны “Экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай” А/677 тоот тушаалаар нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи, эдийн засгийн үнэлгээ шинэчлэн батлагдсан. Уг тушаалаар нэн ховор, ховор, элбэг ургамлын төлбөрийн хэмжээ нэмэгдсэн учраас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дах хэсгийн заалтын дагуу аймгийн байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоохоор тогтоолын төсөл боловсруулан танилцуулж байна.

Манай аймаг ургамал газар зүйн хувьд Хэнтийн уулын тайга, Хангайн уулын ойт хээр, Хөвсгөлийн уулын тайга, Монгол дагуурын ойт хээрийн гэсэн 4 мужлалд хамаардаг онцлогтой бөгөөд байгалийн ургамлын баялаг нөөцтэй аймаг юм.

Гэвч уур амьсгалын дулаарал, цөлжилт, бэлчээрийн хэт ашиглалт /малын тоо толгой болон бэлчээрийн даацыг үл харгалзан олноор бөөгнөрч буй шинэ малчид, хяналтгүй бэлчээрийн талбай/, эдийн засгийн ач холбогдол бүхий газарт учирч буй хэт ачаалал, уул уурхай болон хүний бусад үйл ажиллагааны улмаас байгалийн ургамлын тархацын хүрээ хумигдан, нөөц нь жилээс жилд хомсдож байна. Мөн ойн түймэр, технологийн бус мод бэлтгэлийн сөрөг нөлөөлөл, ойн зах, ойжуулсан талбай тойрсон малын бөөгнөрөл, бэлчээрийн сэлгээгүй ашиглалт, малын тоо толгой нэмэгдсэн зэрэг нь ойн талбай, бэлчээрийг хэт талхалж, тэнд ургаж байгаа байгалийн ургамлууд цөөрөх, устах аюулд өртөж байна. Нэн ховор амьтны нутагладаг газар, ногоон бүс, голын ай сав, баянбүрдэд ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглосон боловч мал бэлчээрлүүлэхийг зөвшөөрсөн байна. Цаг агаарын дулаарал, цөлжилт, бэлчээрийн талхлагдал нь байгалийн ургамлын тархац, нөөцийг өөрчлөх нэг чухал үзүүлэлт болж байна.

Аймгийн нутаг дэвсгэрээс сүүлийн жилүүдэд нэн ховор, ховор, ашигт, эмийн ургамлыг их хэмжээгээр түүж бэлтгэн гадаад руу экспортлож байна. Үүнээс гадна хүн амын өсөлт, иргэдийн хэрэглээ өссөн, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог байдал зэргийг харгалзан үзэж дахин шинэчлэн тогтоох шаардлагатай болж байна.

Аймгийн хэмжээнд ургамлын аймгийн судалгаа одоогоор иж бүрэн хийгдээгүй байгаа ба нэн ховор, ховор, элбэг, ашигт ургамал болон эмийн ургамлын судалгаа, тархац, нөөц, зураглал, тооллого зэргийг мэргэжлийн байгууллагаар нарийвчлан гүйцэтгүүлэхээр аймгийн Худалдан авах ажиллагааны албатай хамтран тендерийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Ургамлын иж бүрэн судалгаа хийлгэснээр нэн ховор, ховор ургамлыг хамгаалах арга хэмжээ авах, жилд ашиглаж болох ургамлын нөөц тодорхой бодиттой болох бөгөөд цаашдаа ургамлын аймгийн мэдээллийн сан бүрдэх ач холболдолтой юм.

Мөн дээрх судалгаа хийгдснээр төлбөр авах ховор, элбэг ургамлын зүйлийн тоо нэмэгдэх боломжтой юм.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Төсөл

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны.....сарын.....өдөр

Дугаар.....

Дархан

“БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН
ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн д, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь заалтыг, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/677 тоот тушаалыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймагт эмийн болон хүнсний зориулалтаар байгалийн ургамал түүж, бэлтгэсний төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д даалгасугай

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Төлбөр, хураамжийн хувь хэмжээ тогтоох тухай 83 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.НАСАНБАТ

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨЛБӨР ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ

9 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

9.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

14 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

14.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний дор дурдсан хувиар тооцон төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	Доод	Дээд
1. Нэн ховор	25	30
2. Ховор	15	20
3. Элбэг	5	10

14.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 14.1-д заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.